



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 18 өдөр

№ 2018/06


Улаанбаатар хот

“Силвэр лайт секюритиз ҮЦК” ХХК-ийг гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.17, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1.1 дахь заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Силвэр лайт секюритиз ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.
2. “Силвэр лайт секюритиз ҮЦК” ХХК-тай “Гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг компанийн Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Силвэр лайт секюритиз ҮЦК” ХХК /Ц.Цэлмүүн/-д үүрэг болгосугай.
4. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.БАТХУЯГ